



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын хураангуй тайлан

Аудитын сэдэв: Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын ТБХ-ны 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2025 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дүгээр тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 онд гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн гүйцэтгэв.

**АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД ЯВУУЛЖ ИРСЭН БАЙНА.**

Аудитын тайланг хүргүүлсэн этгээд: ҮАГ, Санхүү, төрийн сангийн хэлтэс

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Женисбек

Утас: 70422954 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Нурлан

Утас: 99103281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Аудитор: Ж.Назгүл

Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

Аудитор: М.Айнур

Утас: 94159291 Цахим хаяг: Ainurm@audit.gov.mn

Аудитор: М.Бауыржан

Утас: 99169641 Цахим хаяг: bauirjanm@audit.gov.mn

Аудитын харилцан хамаарал:

Аудитыг Монгол улсын Ерөнхий аудиторовын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дагуу хийсэн.

Аудитын зорилго, зорилтууд, хамарсан хүрээ:

Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэлд нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ, аймаг, сумын Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- ✓ Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх;
- ✓ Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх.

Аудитад Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумын санхүүгийн алба, төрийн сангийн 2023-2025 оны үйл ажиллагааг хамруулан төрийн сангийн тогтолцоо оновчтой эсэх, үйл ажиллагаанд хамааралтай хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын гол үр дүн:

1.1. Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актууд холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан орон нутгийн төсвийг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар тухайн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг батлуулж ажилласан байна. Тухайлбал:

Аймгийн Засаг даргын 2022 оны “Орон нутгийн 2023 оны төсвийн сар, улирлын хуваарь батлах тухай” А/1074 дүгээр захирамжаар 2023 оны төсвийн хуваарийг, 2023 оны “Орон нутгийн 2024 оны төсвийн сар, улирлын хуваарь батлах тухай” А/924 дүгээр захирамжаар 2024 оны төсвийн хуваарийг, 2025 оны “Орон нутгийн 2025 оны төсвийн сар, улирлын хуваарь батлах тухай” А/29 дүгээр захирамжаар 2025 оны төсвийн хуваарийг батлуулсан байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс дээрх хуваарийг үндэслэн санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу сар бүр хэлтсийн даргаар батлуулан санхүүжүүлтийг олгосон байна. Сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөөг жил бүр аймгийн Засаг даргаар, дотоод хяналт хийх удирдамжийг хэлтсийн даргаар батлуулан ажиллажээ.

1.2. Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтэц бүрдсэн байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь аймгийн ЗДТГ-ын бүтцэд, сумын санхүүгийн алба, төрийн сан нь сумын ЗДТГ-ын бүтцэд багтан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь хэлтсийн дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогч, нягтлан бодох бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, төсвийн бодлого хариуцсан мэргэжилтэн, төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн тус бүр 1, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн 2 бүгд 8 орон тоогоор ажиллаж байна.

Тус аймгийн 13 сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн албад санхүү албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн тус бүр 1, Цагааннуур тосгонд төсөв, төрийн сангийн мэргэжилтэн 1 бүгд 27 орон тоо ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 263 төсвийн байгууллага үйл ажиллагаа явуулж аймаг, сумын төрийн сангаар үйлчилгээ авчээ.

Аймаг, сумын төрийн санд улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын нийт 1206 данс байршиж байгаагаас аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс 247 дансны, сумуудын төрийн сан 959 дансны орлого, зарлагын гүйлгээг холбогдох хууль, журмын хүрээнд хянан баталгаажуулж ажиллажээ.

Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд аймаг, сумын төрийн санд улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын нийт 22 системийн хэрэглэгч бүртгэлтэй байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумын санхүүгийн алба, төрийн сангийн мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөс батлан гаргасан ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн баталж ажиллажээ.

Цагааннуур тосгонд төлбөр тооцоо хариуцсан нэг мэргэжилтэн ажилладаг бөгөөд тосгоны Захирагчийн албаны нягтлан бодогч нь төрийн сангийн мэргэжилтний үүргийг хариуцсан гүйцэтгэж төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог хянаж, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн нь санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэж гүйлгээг баталгаажуулж байна. Энэ нь Төрийн албаны зөвлөлийн 2025 онд баталсан албан тушаалын тодорхойлолтод нийцээгүй тул Үндэсний аудитын газарт төрийн сангийн бүтцийг Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь заалттай нийцүүлэн зохион байгуулах саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлэх саналыг уламжлав.

2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт батлагдсан төсөв, төсвийн хуваарь, хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн байна.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс нь төсвийн санхүүжилтийн эрх олгох жагсаалтыг сар бүр өссөн дүнгээр журмын 23 дугаар хавсралт маягтын дагуу баталгаажуулж ажиллажээ. Сумдын төрийн сангийн хувьд журмын 2.4.1-2.4.9-д заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор орлоготой уялдуулан олгож ирсэн боловч журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан олгоно гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Тухайлбал: 2023 онд Алтай, Бугат сум, Цагааннуур тосгон, 2024 онд Бугат сум, 2025 онд Бугат, Буянт, Дэлүүн сум журмын 2.6.1-т заасан 23 дугаар хавсралт маягтыг хөтөлж, маягтын дагуу төсвийн байгууллагуудад санхүүжилтийн эрх олгох жагсаалтыг баталгаажуулсан ба бусад сумууд маягтыг зааврын дагуу хөтлөөгүй байна. Энэ нь сумын төрийн санд “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.6.1-т “.....журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан олгоно” гэсэн заалтад хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогыг 2023-2025 онд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлогоос 8 байгууллагад 459.8 сая төгрөгийн, ЗДНХ ба түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 103 байгууллагад 15,110.3 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 68 байгууллагад 20,214.6 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 98 байгууллагад 6,461.0 сая төгрөгийн, нийтдээ 42,245.7 сая төгрөгийн төсвийг үйл ажиллагааны дансаар хүлээн авч зарцуулсан ба түүвэрлэн шалгахад журмын дагуу анхан шатны баримт бүрдлийг хангуулж эрх нээж ажилласан байна.

2.2. Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагаа хууль, журмын дагуу баталгаажин, нэгдсэн хяналттайгаар хэрэгжсэн байна.

Тайлант онуудад төрийн сангийн дансны санхүүжилт, орлого, үлдэгдлийн баталгааг журмын 5 дугаар хавсралтын ТТ-5 маягтын дагуу үйлдэн төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулж ажилласан байна.

Аймаг, сумдын төрийн сангаас төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтээр хийсэн гүйлгээг шалгаж үзэхэд нийт 11,697.7 сая төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар хийсэн 4,607 гүйлгээг буцааж журмын дагуу хянаж ажиллажээ.

Аймаг, сумын хэмжээнд 2023 онд 290 гүйлгээний 123.0 сая төгрөгийн эдийн засгийн ангилал зөрчсөн ба төрийн сангийн шат шатны хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүйгээс 2023 онд 235.7 сая төгрөгийн, 2024 онд 19.7 сая төгрөгийн, 2025 онд 127.7 сая төгрөгийн, нийт 383.1 сая төгрөгийн орлого бууруулсан гүйлгээг баталгаажуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", 37 дугаар зүйлийн 37.1.5-д "төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих", Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.22-т "Бүртгэлийн данснаас дараах тохиолдолд зарцуулах эрх нээхгүй гүйлгээ хийхийг зөвшөөрнө" гэсэн заалттай тус тус нийцээгүй байгаа тул зөвлөмж болгов.

Аймаг, сумдын төрийн сангаас 2023 онд 3675 гүйлгээ, 2024 онд 2806 гүйлгээ, 2025 онд 3031 гүйлгээг буцаасан ба 2023 онд 3468 гүйлгээ, 2024 онд 2159 гүйлгээ, 2025 онд 2345 гүйлгээ амжилтгүй болсон ба төсвийн байгууллагуудаас илгээсэн зарим гүйлгээ төсвийн багц хүрэлцээгүй, төсвийн сар нээгдээгүй, үнийн дүн зөрүүтэй, харилцагчийн дансны мэдээлэл алдаатай зэрэг шалтгаанаар 2023 онд 6,848.7 сая төгрөгийн, 2024 онд 6,578.7 сая төгрөгийн, 2025 онд 8,565.8 сая төгрөгийн гүйлгээ амжилтгүй болсон байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумуудын санхүүгийн алба нь төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсөв хоорондын тооцоо, холбогдох тохируулгын тайлан, мэдээг хугацаандаа гаргаж, тайлагнаж ажилласан байна

2.3. Төрийн сангийн үйл ажиллагаа, хяналтын тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжиж байна

Санхүү, төрийн сангийн хэлтэс нь 2023-2025 онд "Сумдын Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөө"-г аймгийн Засаг даргаар, дотоод хяналт хийх удирдамжийг хэлтсийн даргаар батлуулан ажилласан байна. Тус төлөвлөгөөний дагуу Аймгийн төрийн сангаас сумуудын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн 2023-2025 оны төлөвлөгөөт дотоод хяналт шалгалтад 18 сумын төрийн сангийн үйл ажиллагааг хамруулахаар тусгасан байна. Гүйцэтгэлээр 16 сумын санхүүгийн албадын үйл ажиллагааг хамруулан цахимаар болон газар дээр нь очиж хяналт хийж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн ба төлөвлөгөөний биелэлт 88.9 хувьтай хэрэгжсэн байна.

Сумдын төрийн санд 2023-2025 онд дараах зөвлөмжүүдийг өгч ажилласан байна. Үүнд:

- Эрхийн бүртгэлийн сан систем дэх баримт бичгийн иж бүрдлийг цаасан суурьт гарын үсгийн баталгааны маягтай тулгаж гарсан зөрчлүүдийг арилгах;
- Төрийн сангийн цахим архивыг журналын төлбөрийн хүсэлттэй тулган архивын нэгж үүсгэж ажиллах;
- Нягтлан бодогчдыг зөвшилцөхөд бүрдүүлэх материалын бүрдүүлэлт, нийтлэг гарч буй зөрчлүүдийг арилгах;
- Эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй, зарцуулах эрх нээлгээгүй байхад гүйлгээ хийсэн зөрчлүүдийг залруулах, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ

хийхгүй байх, анхан шатны баримтын иж бүрдлийг ханасан эсэхийг хянаж ажиллах;

- Орлого бууруулж гүйлгээ хийсэн тохиолдолд орлогын хуулга болон байгууллагын хүсэлтийг хавсаргаж ажиллах;
- Төрийн сангийн мэргэжилтэн амралт авах, чөлөө авах хугацаанд журамд заасан маягтын дагуу баримтжуулалт хийж аймгийн төрийн санд бичгээр мэдэгдэх;
- Нэмэлт санхүүжилтийн эрх олгоход бүрдүүлэхэд материалыг батлагдсан маягтын дагуу хөтөлж баримтжуулж ажиллахыг зөвлөмж болгосон байна.

Аймгийн Төрийн сангаас төлөвлөгөөт хяналтыг бүрэн хэрэгжүүлж, нэгтгэлийн тайланд зөвлөмжийн биелэлтийн талаар тодорхой тусгаж байхыг анхаарах шаардлагатай байна.

Аймгийн төрийн сангийн өдөр тутмын гүйлгээг дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн нь хянаж, тулган баталгаажуулж ажилласан ба 2023-2025 онд нийт 72.7 сая төгрөгийн 40 гүйлгээг буцаажээ. Аймгийн төрийн сангаас өдөр тутмын гүйлгээнд дотоод хяналт тавьж баталгаажуулан хяналтын дэлгэц ашиглан түүврийн аргаар хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Сумдын төрийн санд цахим хяналтыг түүвэр байдлаар хэрэгжүүлж алдааг дор бүрд нь залруулга хийлгэж, эдийн засгийн ангилал буруу ашигласан буюу зарцуулах эрх нээлгээгүй шууд эх үүсвэр бууруулж гүйлгээ хийсэн гүйлгээний залруулгыг хийлгүүлж цаашид төсвийн гүйцэтгэлийн үнэн зөв байдлыг ханган, төрийн сангийн журмыг мөрдөж ажиллахыг зөвлөж ажилласан байна.

Сангийн яам болон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тус аймгийн төрийн сангийн үйл ажиллагаанд 2023-2025 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Аудитын дүнгээр дотоод хяналтын тайланг тодорхой тоо мэдээ, нотлох баримтад үндэслэн бэлтгэх, зөвлөмжийн биелэлтийг давтан шалгаж байх, өдөр тутмын хяналтын төлөвлөгөө, удирдамжид хугацааг тодорхой тусгаж батлуулах, сумдын төрийн санд хяналтын дэлгэц ашиглан хийх хяналтын үр дүнг сайжруулахыг зөвлөмж болгов.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт оновчтой байна.
2. Сумын төрийн санд төсвийн байгууллагуудад санхүүжилтийн эрх олгох жагсаалтыг баталгаажуулж ажиллаагүй байна.
3. Төрийн сангийн цахим системийн удирдлага, зохицуулалт, мэдээллийн аюулгүй байдал нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, хэрэгцээ шаардлагыг хангасан байна.
4. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт батлагдсан төсөв, төсвийн хуваарь, хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн байна.

5. Төрийн сангийн төлбөр тооцооны үйл ажиллагаа хууль, журмын дагуу баталгаажин, нэгдсэн хяналттайгаар хэрэгжсэн байна.
6. Дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст:

1. “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.6.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь энэ журмын 2.4.1-2.4.9-д заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор мөн журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан олгоно” гэсэн заалтыг сумуудын төрийн сангаар хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллах;
2. Орлого бууруулах гүйлгээг таслан зогсоож, татан төвлөрүүлэлтийн дансанд зарцуулалтын эрх нээхгүй байх, төсвийн байгууллагуудын өдөр тутмын ажил гүйлгээнд тавих хяналтыг сайжруулж зардлын эдийн засгийн ангилал болон зөрчсөн гүйлгээг гаргахгүй байх;
3. Дотоод хяналтын тайланг тодорхой тоо мэдээ, нотлох баримтад үндэслэн бэлтгэх, зөвлөмжийн биелэлтийг давтан шалгаж үр дүнг тооцож байх, өдөр тутмын хяналтын төлөвлөгөө, удирдамжид хугацааг тодорхой тусгаж батлуулан ажиллах;

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу аудитын тайланг хүлээн авснаас 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:

1. Цагааннуур тосгоны төрийн сангийн бүтцийг Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь заалттай нийцүүлэн зохион байгуулах саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлэх,